

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ЗУРАВДУГААР
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 04

Баянтөхөм

Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 12⁰⁰ цагт хурлын танхимд эхлэв.

Хуралд: Засаг дарга Т.Түвшинбат, Засаг даргын орлогч Ж.Пүрэв-Очир, Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгоншигт, Төхөм (1-р) багийн Засаг дарга Ц.Лхагва, Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн Г.Энхцэцэг, Мал эмнэлгийн байцаагч Н.Хүрэлбаатар, Байгаль орчны мэргэжилтэн Б.Батхүү Хууль эрх зүйн мэргэжилтэн Г.Түвшинжаргал нар оролцов. 85%-ийн ирцтэй байв.

Хурлыг нээж сумын Засаг дарга Т.Түвшинбат үг хэлж, хэлэлцэх асуудлыг танилцуулж батлуулав.

Хэлэлцэх асуудал: 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн хоёр давхар барилгын засварын ажлын тендер зарлах ажлын даалгавар боловсруулах тухай.

Хоёр давхар барилгын засварын ажлын ажлын нийт төсөвт өртөг нь 610,871,690 (зургаан зуун арван сая найман зуун далан нэгэн мянга зургаан зуун ерэн) төгрөгөөр зураг төсөв батлагдсан байгаа. Бид энэ онд 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөр засварын ажлыг эхлүүлэхээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын саналд иргэдээс ирсэн саналын дагуу эрэмбэлэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.

Энэ онд санхүүжүүлэх 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөр засварын ажлын аль ажлуудыг хийлгэх талаар зураг төсөвтэй танилцан шийдвэр гаргаж өгнө үү.

Асуулт: Байгаль орчины асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батхүү

Засварын ажилд энэ онд тендерт шалгарсан ажил гүйцэтгэгч дараа оны ажлаа үргэлжлүүлэн хийхүү.

Хариулт: Засаг даргын орлогч Ж.Пүрэв-Очир

Тендерийг 2024 онд 200,000,000 төгрөгөөр санхүүжүүлэхээр үлдэгдэл санхүүжилтийг 2025 онд санхүүжүүлэхээр 1 тендер зарлана. Энэ онд шалгарсан ажил гүйцэтгэгч дараа онд санхүүжилтээ авч ажлаа үргэлжлүүлнэ гэсэн үг.

Асуулт: ЗДТГ-ын дарга Б.Отгоншигт

Энэ онд барилгын засварын ажилд гадна ямар ажлууд орвол зохистой байна вэ.

Хариулт: Засаг даргын орлогч Ж.Пүрэв-Очир

Энэ оны барилгын засварын ажилд гадна фасадны хөөсөн гадна дулаалга өнгөлгөө, шагретий эмулсээр өнгөлөх, шувуун нурууны дээврийн ажил, цонхнууд шинээр суулгаж гадна амалгаа хийх, гадна хаалгануудыг солих зэрэг ажлуудыг хийлгэхээр, ирэх оны төсвийг бид төсвийн төсөл хэлэлцэх хурлаар үлдэгдэл санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төсөвт суулгана. Ер нь бол тендерт шалгарсан ажил гүйцэтгэгч бидний 2024 онд хийгдэх ажлуудаас илүү ажил хийсэн ч байлаа гэсэн 2025 онд үлдэгдэл ажлаа хийж үлдэгдэл санхүүжилтээ бүтнээр нь авна.

Зөвлөлийн гишүүдээс асуулт гарсангүй асуултыг тасалж саналаа хэлэв.

Санал: Засаг дарга Т.Түвшинбат

Энэ онд төсөвлөсөн 200,000,000 төгрөгөөр хоёр давхар барилгын гадна хөөсөн дулаалга фасад, шувуун нуруун дээвэр, хаалга цонхийг сольж амалгаа хийж гадна ажлын дуусгуулах нь зүйтэй байх, тендерт шалгарсан ажил гүйцэтгэгчээр 2025 оны төсөв батлагдсан дариуд эхний ээлжинд засварын үлдэгдэл ажлыг санхүүжүүлж хийлгэе.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөлийн гишүүд: 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 200,000,000 сая төгрөгний хоёр давхар барилгын ажлын гадна фасадны хөөсөн дулаалга өнгөлгөө, шувуун нуруун дээвэр, цонх хаалга шинээр суурьлуулах, амалгаа хийх зэрэг ажлуудыг эхний засварын ажлаар хийлгэхээр шийдвэрлэлээ.

Сумын Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралдаан 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 12³⁰ минутанд дуусав

ТАНИЛЦСАН:
ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ


Ж.ПҮРЭВ-ОЧИР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН  Г.ТҮВШИНЖАРГАЛ